

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1 Төслийн нэр	2
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	2
1.3 Төслийн хүчин чадал	2
1.4 Төслийн дэд бүтэц	4
1.5 Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн зам	5
1.6 Хог хаягдлын менежмент	6
1.6.1 Хатуу хог хаягдал	6
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	7
2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл	7
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	11
3.1 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим	12
БҮЛЭГ 4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
4.1 Менежментийн төлөвлөгөөний гол зорилт	15
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
6.1 Биологийн олон янзын байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
БҮЛЭГ 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	22
БҮЛЭГ 8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	23
БҮЛЭГ 9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	24
БҮЛЭГ 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	26
БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	28
БҮЛЭГ 12. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ	31
БҮЛЭГ 13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ	33

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг №. 1 Төслийн байршил	3
Зураг №. 2 Ашиглалтын систем	4
Зураг №. 3 Бичигтийн боомт хүртэл тээвэрлэх маршрут	5
Зураг №. 4 Бор-Өндөр хүртэл тээвэрлэх маршрут	5
Зураг №. 5 Дахин боловсруулах хог хаягдлын ангилан ялгалтын жишээ	6
Зураг №. 6 Усан сүлжээний зураг	7
Зураг №. 7 Ургамлын хэв шинж	9
Зураг №. 8 Хөрсний хэв шинж	10

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №. 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	2
Хүснэгт №. 2 Төслийн талбайн координат	2
Хүснэгт №. 3 Уурхайн ажиллах горим	3
Хүснэгт №. 4 Болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим	12
Хүснэгт №. 5 Нөлөөллийн эрчим, цар хүрээ, шанж чанараар ангилсан байдал	13
Хүснэгт №. 6 БОМТ-ний задаргаа	16

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр

Зараа хайлуур жоншны ордыг далд уурхайн аргаар ашиглах төсөл

Төслийн зорилго: “Зараа” хайлуур жоншны ордыг далд уурхайн аргаар ашиглах төслийн үндсэн зорилго нь Монгол Улсын уул уурхайн салбарын дунд болон урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах, хууль эрх зүй, татварын орчинг тогтвортой байлгах, эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгаль орчинд ээлтэй бөгөөд хайлуур жоншны далд уурхайн, боловсруулах техник технологийг сайжруулж алт авалтыг өсгөх, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, уул уурхайн салбараас эдийн засагт оруулах өгөөжийг дээшлүүлэх, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадварыг өсгөхөөр төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодолгын хүрээнд ордын талбайд олборлох үйл ажиллагааг явуулж, ордын нөөцийг ашиглалтын үе шатанд нэмэгдүүлэх, тогтвортой үйл ажиллагаа явуулахад чиглэнэ.

1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Хүснэгт №. 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Ананд баян тал”
Улсын бүртгэлийн дугаар	9011141103
Регистрийн дугаар	5218624
Хаяг	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Консулын, 512-тоот
Утас	99009348


Төслийн байршил: “Ананд баян тал” ХХК-нийн Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын “Зараа” нэртэй хайлуур жоншны орд MV-017194 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь 94 га талбайг хамран оршино. Улаанбаатар хотоос 520 км Баруун-Урт хотоос зүүн тийш 20 км Сүхбаатар сумын төвөөс баруун тийш 35 км-т байрлана.

Хүснэгт №. 2 Төслийн талбайн координат

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	113	29	32.24	46	39	14.73
2	113	29	32.25	46	39	41.75
3	113	28	39.24	46	39	41.75
4	113	28	39.24	46	39	14.73

1.3 Төслийн хүчин чадал

Уурхайн хүчин чадлыг захиалагч байгууллагаас өгсөн төслийн даалгаварыг үндэслэн жилд 50.0 мян.тн хүдэр олборлохоор ТЭЗҮ-д тусгасан байна. Ордын нийт үйлдвэрлэлийн ач холбогдолтой нөөц нь 302.7 мян.тн байна. Далд уурхайн нээлт, ашиглалт болон хаалт, нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх хугацааг оролцуулан уурхайн нийт ажиллах хугацааг 7 жил байхаар тооцсон. Уурхайн хэмжээнд 42 ажилчид ажиллана.



Зураг № 1 Төслийн байршил

Уурхайн ажиллах горим

Уурхай нь бүтэн жил тасралтгүй ажиллах бөгөөд зайлшгүй амрах хоног болон өвлийн улирлын сул зогсолтуудыг доорх хүснэгтэнд үзүүллээ. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 3 ээлжээр 8 цагаар явагдана.

Үйлдвэрлэлийн бусад ажил болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг, тоног төхөөрөмж угсарч монтажлах ажлуудыг үйлдвэрлэлийн дотоод ажлын зохион байгуулалтаар хийнэ.


Хүснэгт №. 3 Уурхайн ажиллах горим

№	Горимын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга
1	Жилийн хуанлийн хоног	Хоног	365
2	Өвлийн улирлын сул зогсолт	Хоног	45
3	Уурхайн жилд ажиллах хоног	Хоног	320
4	Баяр ёслолын амралт	Хоног	7
5	Цаг агаарын саатал	Хоног	7
6	Засвар үйлчилгээ	Хоног	6
7	Жилд ажиллах бодит хоног	Хоног	300
8	Хоногт ажиллах ээлжийн тоо	Ээлж	3
9	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	Цаг	8
10	Цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.9
11	Нэг ээлжин дэх цэвэр ажлын цаг	Цаг	7.2
12	Хоногт ажиллах бодит цаг	Цаг	21.6
13	Жилд ажиллах бодит цаг	Цаг	6480

Уурхайн ашиглалтын систем

Зараагийн хайлуур жоншны ордын ашиглалтад хамгийн тохиромжтой нь хүдэр хоршоолох ашиглалтын систем байна.

Зараагийн хайлуур жоншны ордын ашиглалтад хамгийн тохиромжтой нь хүдэр хоршоолох ашиглалтын систем байна.



Зураг №. 2 Ашиглалтын систем

1.4 Төслийн дэд бүтэц

Зараа-6 орд нь Чингис хотоос 98 км, Сүхбаатар сумаас баруун зүгт 21 км-т орших бөгөөд ордын урд талаар УБ-Дорнод хүртэл хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг.

Уурхайн цахилгаан хангамж:

Одоогоор уурхайд 10/0.4 кВ-ын нэг хүчний трансформатор бүхий 250 кВА-н дэд станц суурилагдсан бөгөөд хүчин чадлыг өргөтгөж бүх хэрэглэгчдийг 0.4кВ-ын цахилгаан эрчим хүчээр тэжээх 10/0.4 кВ-ын нэг хүчний трансформатор бүхий 1,000 кВА-н дэд станц суурилуулахаар төлөвлөсөн байна..


Уурхайн усан хангамж:

Усны эх үүсвэр:


- Өрөмдмөл гүний худаг
- Усны ундарга 3.8 л/сек

1.5 Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн зам

Зараагийн уурхайгаас гарах баяжмалыг нэгдүгээрт Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших Бичигтийн боомт хүртэл, хоёрдугаарт Сүхбаатар аймгийн Бор-Өндөр сум хүртэл авто, цаашаа Замын-Үүд боомт хүртэл төмөр замаар тээвэрлэх 2 хувилбараар тээвэрлэхээр төлөвлөсөн байна. Автотээвэрээр тээвэрлэхэд Бичигтийн боомт хүртэл 268 км, Бор-Өндөр хүртэл 360 км зайтай байна.



Зураг №. 3 Бичигтийн боомт хүртэл тээвэрлэх маршрут



Зураг №. 4 Бор-Өндөр хүртэл тээвэрлэх маршрут

1.6 Хог хаягдлын менежмент

1.6.1 Хатуу хог хаягдал

Уурхайн ажилчдын тосгоны хэмжээнд үүсэх хатуу хог хаягдлыг ахуйн болон машин техникээс сольсон сэлбэг хэрэгслийн гаралтай хаягдал гэж 2 үндсэн хэсэгт хувааж болно. Уул уурхайн ажилчдын тосгоны хувьд ахуйн гаралтай хатуу хог хаягдлын эх үүсвэрт ажиллагсдын амрах байр, гал зуух, ажлын байр, угаалгын өрөө гэсэн үндсэн томоохон объектуудаас хуралддаг.

Уурхайн 2 ээлжээр ажиллах 50 ажилчидтай байх бөгөөд нэг ажилчнаас хоногт дунджаас 0.3 кг ахуйн хатуу хог хаягдал гарна гэж үзвэл хоногт 15 кг, жилд 4500 кг нийт ашиглалтын хугацаанд 22500 кг хаягдал гарна.

“Теем смайл” ХХК-ны хээрийн судалгааны багийг төслийн талбайд ажиллахад төсөл хэрэгжих талбайд уурхайн үйл ажиллагаа түр зогссон байдал, уурхайн гол ам, барилга байгууламж баригдсан байна. Одоогийн байдлаар хог хаягдлын эх үүсвэр нь гал тогоо, ажилчдын байр, машин техникийн тос тосолгооны материал зэргээс хог хаягдал үүсэхээр байна.

Төсөл хэрэгжүүлэгч “Ананд баян тал” ХХК нь Сүхбаатар сумын Байгаль орчны байцаагтай хог хаягдлын гэрээ хийн сумын төвийн нэгдсэн хог хаягдлын цэг рүү ачуулахаар гэрээ хийсэн байна.

Уурхайн үйл ажиллагааны явцад ажилчдын өдөр тутмын ундааны сав, баглаа боодол, цаас, гялгар уут зэрэг ахуйн хатуу хог хаягдлууд гарах болно. Эдгээр хог хаягдлыг дараах байдлаар ангилан төрөлжүүлэн дахин боловсруулагдах хог хаягдлуудыг аймаг бүрт БОАЖЯ-наас өгсөн дахивар хаягдал нягтаршуулан шахах пресслэгч төхөөрөмжөөр овог хэмжээг багасган аймгийн хэмжээнд хэрэгжиж буй аймгийн төвийн хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төсөлд Ананд баян тал ХХК нь оролцон төслийн хүрээнд хог ил задгай хаягдахгүй хяналттай ландфиллын ажил хийгдэн улаан шугам татаж хөрс хуулах ажилд оролцох нь зүйтэй.

Ахуйн хог хаягдал болох хатуу хог хаягдалыг төвлөрсөн цэгт хаяж төвлөрүүлээд сумын хог тээврийн газартай гэрээ хийн сардаа 1-2 удаа төвлөрсөн хогийн цэгт хүргүүлэн хаяж байх нь зүйтэй. Цаашид хогийн цэгийн тохижолтыг сайжруулж, хогыг ангилан ялгаж, эрүүл ахуйд нийцсэн байгаль орчинд сөрөг нөлөө багатайгаар шийдвэрлэх шаардлагатай.

“Төсөл хэрэгжүүлэгч нь 2017 оны 05 сарын 12-нд батлагдсан /шинэчилсэн найруулга/ Хог хаягдлын тухай хуулийн зүйл заалтыг чанд сахин мөрдөн хог хаягдлыг ангилан ялгах дадал зуршлыг уурхайн ажилчдад хэвшүүлэн ажиллах орчныг бүрдүүлэх нь зүйтэй.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл


Сүхбаатар сум нь Монгол орны зүүн бүсэд Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийн хойд хэсэгт, нийслэл Улаанбаатар хотоос зүүн зүгт 520 км, аймгийн төв Баруун-Уртаас 20 км, Эрдэнэцагаан сумын нутагт орших хилийн Бичигт боомтоос 268 км-ийн зайтай оршдог. Мөн улсын хөгжлийн гол тэнхлэг-Мянганы замаас 141 км, бүсийн хөгжлийг тэтгэх босоо тэнхлэгээс 5 км-т /төлөвлөлтөд тусгагдсанаар/ тус тус оршдог. Сумын нутаг дэвсгэрийн баруун урд талаар Уулбаян, Халзан сумдуудтай, баруун талаараа Мөнххаан сум, хойд талаараа Дорнод аймгийн Булган, Хөлөнбуйр сумдуудтай, зүүн талаараа Дорнод аймгийн Матад, зүүн урд талаараа Эрдэнэцагаан сумтай, урд талаараа Асгат сумтай тус тус хиллэдэг.

Далайн түвшнээс дээш 1000-1500 м өргөгдсөн. Нутгийн ихэнх хэсэг нь хадлан тэжээл бэлтгэх, мал аж ахуй, газар тариалан эрхлэхэд нэн тохиромжтой зөөлөн хүрэн бор хөрстэй. Талбулаг, Дүнгэндэг зэрэг рашаан, ус, Бүрдэнэ говь, Их цагаан зэрэг хүнсний давсны нөөц арвинтай газрууд, барилгын төрөл бүрийн зориулалтаар ашиглах боломж бүхий шавар, зосны илэрц, Талбулаг, Салхит, Салаа, Арын нуур, Алтат, Төмөртэй, Тугалбулаг, Дөхөм зэрэг нүүрс өнгөт металлын судлагдсан ордтой.

Ус зүйн сүлжээ:

Төслийн талбай нь ус зүйн хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай савд, Мэнэнгийн талын сав газарт тус тус багтана. Сүхбаатар нь ус зүйн мужлалаар ус багатай бүст багтах бөгөөд гадаргуугийн ус ховортой, тогтмол урсгалтай гол мөрөн байхгүй боловч 20 гаруй жижиг нуур, 200-гаад булаг шанд, гол горхи байдаг.

Сүхбаатар, Хянганы бүсэд тунадас элбэг, гол мөрний сүлжээ шигүү байхад Хэрлэнгээс урагших ухаа гүвээт тал болон Баруун-Урт орчмын цав толгод газарт байнгын урсгалтай гол горхи бараг үгүй юм. Судалгааны баримтаас үзэхэд Хэрлэнгээс урагш орших хуурай хээр тал газарт урсацын модуль 0.1 л/с-ээс бага болох бөгөөд гол горхийн үндсэн тэжээл нь хур тунадас, гүний ус байна. Сүхбаатар аймгийн нутгийн хойд хэсгээр Хэрлэн гол эмжээрлэн урсах бөгөөд зүүн өмнөд, өмнөд хэсэг Чоногол, Харгилтай, Баян зэрэг гол горхи элбэгийн зэрэгцээ Ганга,



Зураг №. 6 Усан сүлжээний зураг

Дагшин, Дуут, Өөшийн Цагаан нуурууд мөн Тал булаг, Цавчирын зэрэг рашаантай. Сүхбаатар аймагт гадаргын болон худаг уст цэгийн тооллогыг 2014 онд зохион байгуулсан дүнгээс үзэхэд нийт гол горхи 69, булаг 307, рашаан 6, нуур 180, худаг 1762, цэвэрлэх байгууламж 2, үерийн хамгаалалтын далан 1, үслалтын систем 2, цооног 16 тус тус тоологдсоноос гол горхи 14, нуур 27, булаг шанд 29 тус тус ширгэсэн дүн гарсан нь ус ашиглалт ба усны хэрэглээ харьцангуй бага боловч уур амьсгалын өөрчлөлт, аж ахуйн үйл ажиллагааны нөлөөгөөр усны горим, нөөц, чанарт өөрчлөлт орж хомсдож байгааг илэрхийлнэ


Ургамал: Сүхбаатар сум нь ургамал газар зүйн мужлалаар Евроазийн хээрийн мужийн, Дагуур Монголын хээрийн провинцийн, Дорнод Монголын хээрийн тойргийн Дарьгангын галт уулсын, Бяруутын, Егузэрийн хээрийн районы хэсэгт хамаарагдана. (А.А.Юнатов, 1976).

Сумын нутгийн баруун, баруун өмнөт хэсэг нь Дарьгангын галт уулын районд, сумын нутгийн төв ба хойт хэсэг нь Бяруутын районд, сумын нутгийн өмнөт, зүүн хэсэг нь Егузэрийн хээрийн районд тус тус багтана. (А.А.Юнатов, Б.Дашням), Дарьгангын галт уулсын район нь тэгш өндөрлөгтэй, том жижиг хүрмэн чулуут дэнж бүхий, галт уулын конус хэлбэрийн оорцог уул энд тэнд тархахын гадна сул хүрмэн чулуу нэлээд тархсан нугачаат тал, хөндийнүүд элбэг тохиолдоно. Энд Хиагийн эзлэх хувь их байхаас гадна 2 зүйлийн Хялгана, Хазаар өвс ихээр ургадаг.

Гол тархах бүлгэмдэл нь Хялганат – хазаар өвс, Хялганат – агь, Хазаар өвст – хялгана - алаг өвс, Хялгана хиагт – алаг өвс, Үетэнт – хазаар өвс эвшлүүд юм. Нам хотос, нарийн хөндийгөөр сийрэгдүү дэрс бүхий улалж – хиагт эвшил бас зонхилон ургадаг. Бяруутын район нь сумын нутгийн төв ба хойт хэсгүүдээр нэлээд их хэмжээний талбайг эзлэх бөгөөд ихэнх бэлчээр нь энд хамаарна. Зүүн хойт чиглэлд сунаж тогтсон нам хотос, хоолойнууд болон тэдгээрийн хооронд орших тэгш ба долгиорхог талууд өргөн уудам нутгийг хамарна. Хотос, хоолой нь маш аажмаар тэгш талруу шилжинэ. Энд алаг цоог, хужир мараат цагаан өнгийн шаварлаг толбууд болон жижиг тойрмууд элбэг тохиолдоно. Гол төлөв дэрс, зарим газраар Бударгана, Таана зонхилон Хиаг, Агь шарилж элбэг ургадаг. Сүхбаатар сумын нутагт Хялганат – хазаар өвст, жижиг үетэн – хялгана – агьт (шарилжит) Хялгана – сөөгт, Хялгана – хиагт, Хялгана – хиаг – алаг өвст, Хиаг - дэрст эвшлүүд тохиолдоно.

Сүүлийн үед зарим зүйлүүдийн ургац удаашран цэцэглэж чадахгүй байдалд орж байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлттэй нэн холбоотой юм. Сүхбаатар сумын нутагт Агь, Биелэг, Улалж, Сонгино, Ортууз, Гичгэнэ, Хунчир, Тарна, Хялгана, Хазаар өвс, Луулийн төрлийн ургамлууд зонхилон ургадаг. Энд 3-4 зүйлийн Хялгана, Хазаар өвс, Агь, Ерхөг, Биелэг, Дааган сүүл, Хиаг, Хиаглай түнх, 4-5 зүйлийн Шарилж, Хонин нүд, Навтуул, Түмэн таана, Өрөмтүүл, Тайжийн жинс, Дагуур хатны цэцэг, Хүж өвс, Хунчир, Гонтиг, Үхэр тарна, Багдай, Ганга зэрэг ургамлууд зонхилдог байна.

Дорнод Монголын хээрийн тойргийн өмнөт хэсэгт ургамлын ерөнхий бүрхэц 40-60% -иас хэтрэхгүй, алаг өвс бүхий хээрт ерөнхий бүрхэц 50% хүрэх нь цөөнгүй. Ургамлын ерөнхий өндөр 10-25 см байдаг. Энд Хялгана – хазаар өвст хээрийн аспект голдуу цайвар ногоон нь хэвийн өнгөтэй байдаг байна. Намар агийн ургалт сэргэж цэцэглэх үед цайвар өнгө улам тодорч бууралдуу өнгөтэй болно. Хэрэв Хонин нүд элбэг бол цагаан өнгөтэй болдог.



Зураг №. 7 Ургамлын хэв шинж

Хөрс: “Зараа” хайлуур жоншны орд байрлах Сүхбаатар сумын нутаг нь Төв Азийн их муж Хангайн дэд муж Монгол дорнодын тойрогт хамаарагддаг байна. Тус нутгийн хөрс нь делюви, элюви, аллювийн хурдас дээр үүсч тогтсон. Хүрэн хөрс нь ихэвчлэн делювийн хөвсгөр хурдас дээр, уулын хөрс нь элювийн хурдас дээр, голын хөндийн хөрс нь аллювийн жижиг бөөрөнхий хайрга чулуун дээр үүссэн.

Хар хүрэн хөрс: Хар хүрэн хөрс нь Сүхбаатар сумын 2% ийг эзэлнэ. Дангаараа үргэлжилсэн бүс үүсгэж чадахгүй алаг цоог тархана. Энэ хөрсний ялзмагт үеийн зузаан нь дунджаар 32-38см-ын хооронд хэлбэлзэнэ. Карбонатын бөөгнөрөл 32-37см-ийн гүнээс ажиглагдана, хөрсний давхаргад гөлтгөнө огт байхгүй. Хар хүрэн хөрс нь хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Делювийн хурдас дээр үүсч тогтсон хар хүрэн хөрс нь дээд давхарга нь бараан хүрэн өнгөтэй, бөөмөнцөр бүтэцтэй, ялзмагт үе нь нэлээн зузаан, хөрсний давхарга нь нягтарч дагтаршсан хайрга чулуу харьцангуй бага, 45-50см-ийн гүнээс карбонатлаг бөөгнөрөл нь үгүй болно.


Хүрэн хөрс: Хүрэн хөрс нь Сүхбаатар сумын 80% ийг эзэлнэ. Энэ хөрс нь ихэвчлэн долгиорхог тэгш тал газраар тархсан байна.

Дов толгодын хөрс: Дов толгодын хөрс нь Сүхбаатар сумын 6% ийг эзэлнэ. Дов толгодын орой, налуу, хажуугаар элюви-делювийн болон элювийн хурдас дээр үүсэж тогтсон. Дов толгодын хүрэн хөрсний ялзмагт үеийн зузаан нь дунджаар 20см байна. Энэ хөрсөнд карбонатын бөөгнөрөл 24см-ын гүнээс ажиглагдана. Дов толгодын хүрэн хөрс нь үе дахрагуудын хөгжил муу, хөрсний үндсэн чулуулаг өнгөн давхаргад ойрхон, өнгөн гадаргуудаа жижиг чулуурхаг, ялзмагт үе нимгэн зэрэг физик шинж чанартай байдаг.

Нугын хөрс: Нугын хөрсний Сүхбаатар сумын 5% ийг эзэлнэ. Нугын хөрсний 2 төрлийн шинж /нугын хар хүрэн хөрс, нугын хүрэн хөрс/ илэрнэ. Нугын хөрс үүсэх нөхцөл нь чийглэг, ургамлын хувьд сайн, делювийн хөвсгөр карбонатлаг хурдас дээр үүснэ. Дов толгод хооронд нам дор газар, нарийхан хөндийд тархсан байдаг. Тухайн сумын хөрсөнд хуучин нугын үлдэгдэл шинж нэлээд илэрч байна.

Нугын хүрэн хөрс гол төлөв дов толгод, уулсын хооронд нарийн хөндийд нам дор газар тархах ба дельювийн хурдас дээр үүсэж тогтсон байна. Энэ хөрс нь механик бүрэлдэхүүн, чулуурхаг болон карбонатлаг байдлаараа хоорондоо ялгаатай. Ялзмагт үеийн зузаан нь 47см байх ба 18-50см-ын хооронд ажиглагдана. Нугын хүрэн хөрс нь давслаг, сийрэг, бөөмөнцөр зэрэг физик шинж чанарыг агуулдаг.

Голын хөндийн хөрс: Голын хөндийн хөрс нь Сүхбаатар сумын 7% ийг эзэлнэ. Аллювийн гаралтай өөрөөр хэлбэл урсгал буюу голын усны нөлөөн дор үүссэн хөрсүүд багтана. Ийм хөрс үүсэх гол нөлөөг ус үзүүлнэ. Тухайн бүс нутгийн ус чийг ихтэй нам дор газар буюу голуудын сав газраар тархсан. Энэ хөрсний онцлог нь газрын гадарга нь нугархаг зүлэгжсэн байна. Аллювийн нугын хөрсний өнгөн гадарга нь дов сондуул ихтэй, микро гадарга илүү хөгжсөн, ус чийг элбэгтэй, түүнд зонхилсон намгийн өвслөг, дэрслэг сөөг голлосон ургамлын дор явагдана. Ялзмагт үе нь харавтар саарал, хөх саарал өнгөтэй доошлох тусам элсэрхэг болж харилцан адилгүй өнгөтэй ба механик бүрэлдэхүүн нь үелэн тогтсон байдгаараа бусад хөрснөөс онцлогтой юм.



Зураг №. 8 Хөрсний хэв шинж

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл: Хөрс хуулах, хүдэр олборлох үед тоос, шороо ихээр үүсгэнэ. Уурхайн овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос, шороо, уурхайд ажиллах машин техникүүдийн шингэн түлшний шаталтаас ялгарах утаа, хөө тортог, хорт хийнүүд, ажилчидын суурингаас гарах хатуу шингэн хог хаягдлын бохирдол, өрөмдлөг, тэсэлгээний ажил хийх үед гарах тоос, шороо, хөрс хуулах, түрэх, тээвэрлэх, элс угаах зэрэг бүхий л ажиллагаа тасралтгүй явагдах тул бульдозер, экскаватор, автомашин, бусад төхөөрөмжийн дуу чимээ болон хорт хий утаа гарах, тоос шороо дэгдэх зэргээр агаар орчныг бохирдуулж, хүний эруул мэнд, хурээлэн буй орчинд сөргөөр нөлөөлнө.

Газрын гадарга болон хэвлийд үзүүлэх нөлөөлөл: Төслийн зүгээс газрын гадарга болон хэвлийд үзүүлэх гол нөлөөлөл нь барилга угсралтын ажил болон төслийн үйл ажиллагаатай холбоотой уурхайн карьер, овоолго болон тээврийн хөдөлгөөн зэрэг эх үүсвэрүүдээс үүснэ.

Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл : Төслийн хүрээнд төлөвлөж буй далд уурхайн барилга байгууламжид хөрс удаан хугацаанд дарагдана. Түүнчлэн дэд бутцийн барилга, байгууламжийн ойр орчимд машин техник, хүний үйл ажиллагаагаар элэгдэл, эвдрэл, бохирдол их үүснэ. Уурхайн үйл ажиллагааны явцад нүүрс-ус буюу шатахуун, түүнтэй төстэй бутээгдэхүүн, мөн химийн бодисын асгаралт, шүүрэлтээс хөрс бохирдох боломжтой. Шатахуун болон химийн бодисын агуулах, сав, машин техникийн тээвэрлэлт ачаалалтын үед асгаралт үүсэж хөрсний боломжит бохирдол ихэнхдээ үүсдэг.

Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл: Хөрс хуулалт болон барилга угсралтын явцад тоосжилт дарахад цэвэр усны нөөц хомсдох, Уулын малталтын үед хөрсний болон гүний усыг зайлуулж усны нөөц хомсдох, Барилга угсралтын ажлын явцад барилгын материал хур тунадас болон үерийн усаар угаагдан барилгын материалд агуулагдах бодисууд хөрсөнд нэвчих, улмаар хөрсний бага гүний усыг бохирдуулах, Баяжуулах үйл ажиллагаа явуулахад химийн бодис алдагдахаас үүдэн хөрсний болон гүний усыг бохирдуулах, Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах савыг соруулах үед асгарч газрын хэвлий болон хөрсийг бохирдуулхаас үүдэн хөрсний усыг бохирдуулах, Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах сав хүчтэй аадар бороо болон үерийн усаар дүүрч хальхаас үүдэн хөрсөнд нэвчиж хөрсний ус болон бага гүний усыг борхирдуулах эрсдэлтэй байна.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл: Төслийн талбайд дэд бүтэц байгуулах, шимт хөрсний болон хаягдал чулуулгийн овоолго бий болгох, уурхайн зам, дэд бүтцүүдийн барилгын ажил хийгдэх зэрэгтэй холбоотойгоор хөрс хуулалт явагдах ба эдгээр үйл ажиллагаа нь ургамлан нөмрөгт шууд болон шууд бус нөлөөллийг үзүүлнэ. Мөн уурхайн байнгын үйл ажиллагаа ургамлан нөмрөгт дам нөлөөлөл богино ба урт хугацаанд үзүүлсээр байх юм.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл: Барилга угсралтын үед ажиллах хүнд даацын автомашин, техник хэрэгслүүдийн дуу чимээнээс амьтад үргэн дайжих, Ургамлан нөмрөгт төслийн үйл ажиллагааны явцад ялгарсан, асгарсан бохирдуулагч материалууд хуримтлагдсанаас өвсөн тэжээлтэн амьтад хордох, Тоосжилтын улмаас ургамал ургах чадвараа алдан ургамлын арви багассанаас өвсөн тэжээлтнүүд хоол тэжээлийн хомсдолд орох, Төслийн ажилчид санаандгүй болон санаатайгаар амьтадыг устгаж болзошгүй, Шувууд утаанд хордох, цахилгаан хүчдэлд цохиулах зэрэг багтана.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл: Төслийг хэрэгжүүлэхэд ажиллах хүчийг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн оршин суугчдаас авч ажиллуулах нь оршин суугчдын амжиргаа, нийгэм эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

3.1 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Аливаа төслийн үйл ажиллагаанаас тухайн орон нутгийн байгаль орчны төлөв байдал, нийгэм, эдийн засаг болон хүн амын амьдрах орчинд хэрхэн нөлөөлөх, тэдгээр нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчимшил зэргийг тогтооход магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргыг өргөн хэрэглэдэг. Энэ арга нь экспертүүдийн гаргасан үнэлэлт, дүгнэлтүүдийг магадлалын онолд тулгуурлан боловсруудах замаар хэрэгждэг. Магадлан жагсаах арга нь нөлөөлөх зүйл байна, байхгүй гэсэн зарчмаар үнэлэх бөгөөд нөлөөлөл байвал “х”-ээр тэмдэглэнэ. Ингэхдээ уг үнэлгээнд оролцсон шинжээч, судлаачдын дүгнэлтийг үндэслэн 2 төрлийн жагсаалт гаргасан. Нөлөөллийн хэлбэр нь үргэлжлэх хугацаа, эрчмийг илрүүлэхэд зориулагдсан бөгөөд нөлөөлөл нь “шууд”, “шууд бус”, “буцаж нөлөөлөх”, “буцалтгүй нөлөөлөх”, давхардах эсэхийг тодруулах, хугацааны хувьд “богино хугацааны”, “урт хугацааны”, эрчмийн хувьд “бага зэрэг”, “дунд”, “хүчтэй” гэхчилэн ангилсан магадлах жагсаах аргаар тодорхойлсон. Доорх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №. 4 Болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

№	Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөл			Хугацаа		Давтамж		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Сулавтар нөлөөлөх	Дунд зураг нөлөөлөх	Хүчтэй нөлөөлөх
Биологийн төрөл зүйлийн оршин амьдрах нөхцөл											
1	Газрын доорх усны чанар		х		х			х	х		
2	Газрын доорх усны нөөц		х			х		х	х		
3	Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х	х		х		
4	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		х								
Байгаль орчны чанарын өөрчлөлт											
5	Усны чанар, хэмжээ		х		х		х			х	
6	Агаарын бохирдол		х		х			х	х		
7	Хөрсний бохирдол		х			х	х		х		
8	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл		х		х			х		х	
9	Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	х							х		
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл											
10	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+				+		+		+	
11	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх										
12	Хүн, амын орлого нэмэгдэх	+				+		+		+	
13	Хүн амын тоо өөрчлөгдөх										
Эдийн засаг, байгаль орчин											
14	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	+		+		+		+		+	
15	Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+		+			+

16	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		+			+		+	+		
17	Ажлын байр нэмэгдэх	+				+	+			+	
18	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+		+			+	
19	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		х		х		х				х
Бусад нөлөөлөл											
20	Хог хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих		х		х		х			х	
21	Нөлөөллийн тоо ширхэг	Сөрөг	2	9		6	3	5	4	7	3
		Эерэг	6	1	1	1	6	2	5	2	4

Тайлбар: “+” эерэг, “х” сөрөг

Хүснэгт №. 5 Нөлөөллийн эрчим, цар хүрээ, шанж чанараар ангилсан байдал

Шууд нөлөөллийн тоо: 8	
Эерэг нөлөөлөл нь: 6	Сөрөг нөлөөлөл нь: 2
<ul style="list-style-type: none"> - Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх - Хүн, амын орлого нэмэгдэх - Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх - Орон нутгийн орлого нэмэгдэх - Ажлын байр нэмэгдэх - Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх 	<ul style="list-style-type: none"> - Хөрсний элэгдэл, эвдрэл - Дуу чимээ, шуугианы нөлөө
Шууд бус нөлөөллийн тоо: 10	
Эерэг нөлөөлөл нь: 1	Сөрөг нөлөөлөл нь: 9
<ul style="list-style-type: none"> - Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох 	<ul style="list-style-type: none"> - Газрын доорх усны чанар - Усны чанар, хэмжээ - Агаарын бохирдол - Хөрсний бохирдол - Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл - Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх - Ахуйн хог хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих
Өөрөө зохицуулагдах нөлөөллийн тоо: 1	
Эерэг нөлөөлөл нь: 1	Сөрөг нөлөөлөл нь:
<ul style="list-style-type: none"> - Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх 	
Богино хугацааны нөлөөллийн тоо: 7	
Сөрөг нөлөөлөл нь: 6	Эерэг нөлөөлөл нь: 1
<ul style="list-style-type: none"> - Усны чанар, хэмжээ - Агаарын бохирдол - Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл - Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх - Ахуйн хог хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих 	<ul style="list-style-type: none"> - Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
Урт хугацааны нөлөөллийн тоо : 9	
Сөрөг нөлөөлөл нь: 3	Эерэг нөлөөлөл нь: 6

<ul style="list-style-type: none"> - Газрын доорх усны чанар - Хөрсний элэгдэл, эвдрэл - Хөрсний бохирдол 	<ul style="list-style-type: none"> - Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх - Хүн, амын орлого нэмэгдэх - Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх - Орон нутгийн орлого нэмэгдэх - Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох - Ажлын байр нэмэгдэх
Буцах нөлөөллийн тоо: 7	
Сөрөг нөлөөлөл нь: 5	Эерэг нөлөөлөл нь: 2
<ul style="list-style-type: none"> - Хөрсний элэгдэл, эвдрэл - Усны чанар, хэмжээ - Хөрсний бохирдол - Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх - Ахуйн хог хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих 	<ul style="list-style-type: none"> - Ажлын байр нэмэгдэх - Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
Буцалтгүй нөлөөллийн тоо: 9	
Сөрөг нөлөөлөл нь: 4	Эерэг нөлөөлөл нь: 5
<ul style="list-style-type: none"> - Газрын доорх усны чанар - Газрын доорх усны нөөц - Агаарын бохирдол - Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл 	<ul style="list-style-type: none"> - Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх - Хүн, амын орлого нэмэгдэх - Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх - Орон нутгийн орлого нэмэгдэх - Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
Сулавтар нөлөөллийн тоо: 9	
Сөрөг нөлөөлөл нь: 7	Эерэг нөлөөлөл нь: 2
<ul style="list-style-type: none"> - Газрын доорх усны чанар - Газрын доорх усны нөөц - Агаарын бохирдол - Хөрсний бохирдол - Дуу чимээ, шуугианы нөлөөлөл - Ахуйн хог хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржил 	<ul style="list-style-type: none"> - Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох - Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
Дунд зэргийн нөлөөллийн тоо: 7	
Сөрөг нөлөөлөл нь: 3	Эерэг нөлөөлөл нь: 4
<ul style="list-style-type: none"> - Усны чанар, хэмжээ - Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл - Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх 	<ul style="list-style-type: none"> - Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх - Хүн, амын орлого нэмэгдэх - Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх - Ажлын байр нэмэгдэх
Эрчимтэй нөлөөллийн тоо : 1	
Сөрөг нөлөөлөл нь: 0	Эерэг нөлөөлөл нь: 1
	<ul style="list-style-type: none"> - Орон нутгийн орлого нэмэгдэх

БҮЛЭГ 4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 Менежментийн төлөвлөгөөний гол зорилт

